



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/102/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2022.02.21 № 15

танай _____ -ны № _____ -т

ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНХАНД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020705

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,024,532.00	89,618,653.00
33	АВЛАГА	-	30,511.00
335	Бусад авлага	-	30,511.00
3351	Байгууллагаас авах авлага	-	30,511.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,024,532.00	89,588,142.00
351	Түүхий эд материал	1,995,400.00	3,449,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,995,400.00	3,449,000.00
354	Хангамжийн материал	75,754,132.00	78,864,142.00
35410	Бичиг хэргийн материал	1,465,278.00	1,924,778.00
35420	Аж ахуйн материал	71,735,954.00	74,984,964.00
35450	Барилгын засварын материал	2,552,900.00	1,954,400.00
35600	Мал амьтад	7,275,000.00	7,275,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,051,589,577.74	3,857,890,927.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,051,589,577.74	3,857,890,927.90
392	Биет хөрөнгө	3,883,451,197.74	3,689,927,547.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,129,780,878.90	4,133,280,878.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(437,512,813.95)	(636,373,347.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	130,197,658.55	130,197,658.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	(72,763,716.53)	(90,127,082.13)
39205	Машин тоног төхөөрөмж	227,865,669.00	269,181,109.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(149,399,842.84)	(177,221,043.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,577,854.00	129,253,554.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,294,489.39)	(68,264,178.63)
393	Биет бус хөрөнгө	168,138,380.00	167,963,380.04
39301	Програм хангамж	350,000.00	350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(174,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	167,788,380.00	167,788,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,136,614,109.74	3,947,509,580.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	35,102.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	35,102.90
413	Өглөг	-	35,102.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	35,102.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,136,614,109.74	3,947,474,478.00
51	Засгийн газрын хувь оролцоо	4,136,614,109.74	3,947,474,478.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,803,037.00	892,803,037.00
51101	Өмч: - төрийн	892,803,037.00	892,803,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,243,811,072.74	3,054,671,441.00
51210	Өмнөх үеийн үр дүн	3,431,446,355.09	3,243,811,072.74
51220	Тайлант үеийн үр дүн	(187,635,282.35)	(189,139,631.74)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,136,614,109.74	3,947,509,580.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	480,794,264.55	695,035,912.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,222,090.55	154,652,285.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,222,090.55	154,652,285.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,222,090.55	154,652,285.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	870,000.00	30,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	67,352,090.55	154,622,285.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,572,174.00	540,383,627.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,388,374.00	180,111,727.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,870,000.00	100,241,490.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,044,274.00	42,873,639.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,474,100.00	36,996,598.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	350,183,800.00	360,271,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	350,183,800.00	360,271,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	659,002,275.06	882,498,541.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	659,002,275.06	882,498,541.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620,916,208.65	811,679,736.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,365,255.00	204,730,349.36
210101	Үндсэн цалин	176,514,100.00	152,037,153.00
210102	Нэмэгдэл	18,071,300.00	46,629,034.36
210104	Урамшуулал	2,680,055.00	6,064,162.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,099,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,295,815.59	25,770,651.00
210201	Тэтгэврийн даатгал	17,426,758.28	18,077,378.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,037,850.50	2,007,991.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,630,288.59	1,606,393.77
210204	Ажилгүйдлийн даатгал	380,041.03	370,809.44
210205	Эрүүл мэндийн даатгал	3,820,877.19	3,708,077.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,787,262.00	28,380,262.42
210301	Гэрэл, цахилгаан	2,929,045.00	3,110,980.69
210302	Тулш, халаалт	12,891,189.00	13,046,302.90
210303	Цэвэр, бохир ус	967,028.00	12,222,978.83
2104	Хангамж, бараа материалын зардал	47,640,302.00	58,124,304.56
210401	Бичиг хэрэг	3,930,650.00	3,377,300.00
210402	Тээвэр, шатахуун	23,314,110.00	31,978,556.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,288,000.00	1,508,448.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,000.00	499,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,037,230.00	18,580,140.00

210408	Бараа материал акталсны зардал	13,063,312.00	2,180,360.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,082,300.00	3,665,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	539,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	12,543,300.00	1,165,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,935,500.00	4,902,000.00
210702	Дотоод албан томилолт	4,935,500.00	4,902,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,706,705.00	22,760,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,647,634.00	21,245,163.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	365,025.00	306,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,046.00	199,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,000.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	1,667,000.00	725,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	283,103,069.06	463,345,781.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,683,580.00	197,813,359.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,914,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	267,419,489.06	261,618,422.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,086,066.41	70,818,804.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,136,030.00	22,595,600.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	2,898,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,950,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,446,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,136,030.00	3,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,950,036.41	48,223,204.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,950,036.41	48,223,204.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(178,208,010.51)	(187,462,629.50)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,427,271.84	1,677,002.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,427,271.84	1,677,002.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(9,427,271.84)	(1,677,002.24)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(187,635,282.35)	(189,139,631.74)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	892,803,037.00	3,431,446,355.09	4,324,249,392.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,803,037.00	3,431,446,355.09	4,324,249,392.09
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00	3,431,446,355.09	4,324,249,392.09
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	892,803,037.00	3,431,446,355.09	4,324,249,392.09

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	892,803,037.00	3,243,811,072.74	4,136,614,109.74
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,785,606,074.00	6,675,257,427.83	8,460,863,501.83
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	892,803,037.00	3,243,811,072.74	4,136,614,109.74
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,678,409,111.00	9,919,068,500.57	12,597,477,611.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	413,442,174.00	540,413,627.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	870,000.00	30,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	870,000.00	30,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	870,000.00	30,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	870,000.00	30,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,572,174.00	540,383,627.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,388,374.00	180,111,727.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,870,000.00	100,241,490.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,044,274.00	42,873,639.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,474,100.00	36,996,598.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	350,183,800.00	360,271,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	350,183,800.00	360,271,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	381,503,304.00	524,142,127.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,503,304.00	524,142,127.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,417,237.59	441,583,422.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,365,255.00	204,760,860.36
210101	Үндсэн цалин	176,514,100.00	152,067,664.00
210102	Нэмэгдэл	18,071,300.00	46,629,034.36
210104	Урамшуулал	2,680,055.00	6,064,162.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,099,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,295,815.59	25,770,651.00
210201	Тэтгэврийн даатгал	17,426,758.28	18,077,378.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,037,850.50	2,007,991.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,630,288.59	1,606,393.77
210204	Ажилгүйдлийн даатгал	380,041.03	370,809.44
210205	Эрүүл мэндийн даатгал	3,820,877.19	3,708,077.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,787,262.00	28,945,159.52
210301	Гэрэл, цахилгаан	2,929,045.00	3,110,980.69
210302	Түлш, халаалт	12,891,189.00	13,611,200.00
210303	Цэвэр, бохир ус	967,028.00	12,222,978.83

2104	Хангамж, бараа материалын зардал	31,724,970.00	29,974,808.56
210401	Бичиг хэрэг	3,928,750.00	3,219,400.00
210402	Тээвэр, шатахуун	23,314,110.00	23,277,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,288,000.00	1,508,448.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,000.00	499,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,187,110.00	1,469,760.00
2105	Нормативт зардал	92,950.00	3,890,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	92,950.00	3,890,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,549,800.00	21,392,995.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,136,500.00	2,500,000.00
210602	Тавилга	600,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	460,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	12,353,300.00	18,692,995.00
2107	Томилолт, зочны зардал	4,935,500.00	4,902,000.00
210702	Дотоод албан томилолт	4,935,500.00	4,902,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,706,705.00	23,185,414.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,647,634.00	21,670,089.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	365,025.00	312,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,046.00	193,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	51,000.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	1,667,000.00	725,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,958,980.00	98,761,534.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,958,980.00	93,817,934.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,943,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,086,066.41	82,558,704.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,136,030.00	34,335,500.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	2,898,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,950,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,446,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,136,030.00	15,039,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,950,036.41	48,223,204.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,950,036.41	48,223,204.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,938,870.00</u>	<u>16,271,500.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,938,870.00	16,271,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,938,870.00	16,271,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,938,870.00	16,271,500.00
223001	Бусад хөрөнгө	31,938,870.00	745,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	15,526,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(31,938,870.00)</u>	<u>(16,271,500.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	360,271,900.00	349,714,348.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,921,900.00	336,364,448.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,086,400.00	312,528,948.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,401,700.00	204,760,860.36
210101	Үндсэн цалин	156,791,900.00	152,067,664.00
210102	Нэмэгдэл	46,629,300.00	46,629,034.36
210104	Урамшуулал	7,980,500.00	6,064,162.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,979,400.00	25,770,651.00
210201	Тэтгэврийн даатгал	19,501,900.00	18,077,378.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,144,200.00	2,007,991.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,715,300.00	1,606,393.77
210204	Ажилгүйдлийн даатгал	419,900.00	370,809.44
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,100.00	3,708,077.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,615,900.00	17,561,608.69
210301	Гэрэл, цахилгаан	3,164,700.00	3,110,980.69
210302	Түлш, халаалт	13,611,200.00	13,611,200.00
210303	Цэвэр, бохир ус	840,000.00	839,428.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,117,300.00	23,113,808.56
210401	Бичиг хэрэг	3,011,300.00	3,008,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,627,700.00	16,627,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,508,500.00	1,508,448.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	499,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,469,800.00	1,469,760.00
2105	Нормативт зардал	3,890,000.00	3,890,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,890,000.00	3,890,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,781,000.00	16,780,995.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	16,581,000.00	16,580,995.00
2107	Томилолт, зочны зардал	6,552,000.00	4,902,000.00
210702	Дотоод албан томилолт	6,552,000.00	4,902,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,515,400.00	1,515,325.00
210803	Даатгалын үйлчилгээ	312,100.00	312,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,000.00	193,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	725,300.00	725,300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,233,700.00	14,233,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,619,700.00	13,619,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	614,000.00	614,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,835,500.00	23,835,500.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,835,500.00	23,835,500.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,898,700.00	2,898,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,950,000.00	4,950,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,446,900.00	11,446,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,539,900.00	4,539,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,350,000.00	13,349,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,350,000.00	13,349,900.00
223001	Бусад хөрөнгө	13,350,000.00	13,349,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	360,271,900.00	349,684,348.61
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	360,271,900.00	349,684,348.61
122005	Орон нутгийн төсвөөс	360,271,900.00	349,684,348.61
62001	Нийт ажилчин	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,476,073.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,476,073.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,976,073.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,383,550.83
210303	Цэвэр, бохир ус	11,383,550.83
2104	Хангамж, бараа материалын зардал	6,861,000.00
210401	Бичиг хэрэг	211,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,877,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,765,600.00
210604	Урсгал засвар	2,112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,670,089.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,670,089.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,183,834.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,854,234.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,329,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,635,653.17
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	37,635,653.17
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	180,111,727.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,111,727.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,241,490.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,873,639.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,996,598.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэйгээр чанартай, тогтмол хүргэж, Засаг дарга, түүний Тамгын газрыг өндөр бүтээмжтэй хэвийн ажиллах бүх нөхцөлөөр хангасан чадварлаг төрийн захиргааны мэргэшсэн албыг бүрдүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 09 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, 6 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын нийт хөрөнгийн 3,947,479.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 39,474.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 27,632.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,104.5 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хөрөнгийн данс нь эргэлтийн бус хөрөнгийн данс бөгөөд 972,160.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн данс нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
АВЛАГА	-	30.5	30.5
БАРАА МАТЕРИАЛ	85,024.5	89,588.1	4,563.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,051,589.6	3,857,890.9	(193,698.6)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,136,614.1	3,947,509.6	(189,104.5)
Өглөг	-	35.1	35.1
Засгийн газрын хувь оролцоо	4,136,614.1	3,947,474.5	(189,139.6)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,136,614.1	3,947,509.6	(189,104.5)

Бараа материал дансны үлдэгдэл 89,588.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,563.6 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын өсөлт байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 2,921.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 12,604.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 26,458.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 27,611.4 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан байна. Мөн 2,029.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг актлан, данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,947,474.4 мянган төгрөг болж 189,139.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 353,383.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 353,383.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 6,888.0 мянган төгрөгөөр өсгөн 360,271.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн өсөлт нь цар тахлын үеийн бэлэн байдлын зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 360,271.9 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 360,271.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 97.1 хувийг зарцуулж, 10,587.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 349,684.3 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу үйл ажиллагаагаа явуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 42,873.6 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламжаар 100,241.5 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 36,996.6 мянган төгрөг, нийт 180,111.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 142,476.0 мянган төгрөгийг зарцуулж, 37,635.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын үндсэн хөрөнгө 18,759.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 9,104.9 мянган төгрөг нь өөрийн хөрөнгөөр 9,655.0 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар ирсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ковидын нөхцөл байдал болон хаврын шороон шуурганы аюултай үзэгдэлд хүнд гарз хохирол амссан нутгийн иргэддээ тухайн нутагт хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлтэй уул уурхайн 15 компани 73,300.0 мянган төгрөг, зам ашигласан 2 компани 12,000.0 мянган төгрөг, нутгийн зөвлөл 1,500.0 мянган төгрөг, нутгийн иргэдээс 14,941.5 мянган төгрөг нийт 100,241.5 мянган төгрөгийн хандивыг өгсөн байна.

Тухайн хандивын мөнгийг нутгийн Улсын онцгой комиссын үйл ажиллагаанд, гэр оронгүй болсон иргэдэд шинэ гэр, 7 оюутны сургалтын төлбөрт тус бүр 1,000.0 мянган төгрөг, малчдад нүүхэд зориулж шатахууны зардал зэрэгт зарцуулж, үлдэгдэл 18,746.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 589,945.7 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож, 499,060.3 мянган төгрөгийн 19 мэдээллийг мэдээлээгүй, хэрэгжилт 86 хувьтай байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,900.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,121.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 35.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 205.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16,881.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд байгууллагад өгөх 35.1 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнаагүй. /Түлш халаалт/;

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 205.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Албан хаагчдад 205.8 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 16,881.0 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Төсвөөс 12,604.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил 3,890.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн.
2. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 386.1 мянган төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан
3. Тайлант хугацаанд 4 мэдээллийг хугацаа хоцроож, 19 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Төсвөөс 12,604,900.00 төгрөгийн тавилга эд хогшил 3,890,000.00 төгрөгийн ажлын хувцас худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн	1	16,494.9					1	16,494.9		
2	Тайлант хугацаанд 4 мэдээллийг хугацаа хоцроож, 19 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй	1						1			
	Дүн	2	16,494.9					2	16,494.9		
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Санхүүгийн тайланд байгууллагад өгөх өр төлбөрийг тайлагнаагүй.	1		1	35.1						
2	Албан хаагчдад 205,835.00 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон	1				1	205.8				
3	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 386,089 төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан	1						1	386.1		
	Дүн	3	0	1	35.1	1	205.8	1	386.1	0	0
	Нийт дүн	5	16,494.9	1	35.1	1	205.8	3	16,881.0	0	0

